

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2013 оны 12 сарын 12

дугаар 506

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” батлах тухай

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд /цаашид “зохицуулалттай этгээд” гэх/-д тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, салбар нээж ажиллуулах хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц, оноосон нэр өөрчлөх, тохиромжтой этгээдийг тодорхойлох, гүйцэтгэх захирлыг томилохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмын 1.4.1-1.4.10, 1.4.16-д заасан зохицуулалттай үйл ажиллагааг энэ журмаар, 1.4.11-1.4.15-д заасан зохицуулалттай үйл ажиллагааг тус тусын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан журмаар зохицуулна.

1.3. Тусгай зөвшөөрлийг олгохдоо үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд төрөөс баримталж буй бодлого, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, ил тод, үр ашигтай, шударга байх зарчмыг баримтална.

1.4. Хорооноос зохицуулалттай этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1, Банкны тухай хуулийн 6.2.7 дахь заалтад заасан дараах зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно:

1.4.1. үнэт цаасны брокерийн;

1.4.2. үнэт цаасны дилерийн;

1.4.3. үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн;

1.4.4. андеррайтерийн;

1.4.5. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн;

1.4.6. үнэт цаасны арилжааны тооцооны;

1.4.7. үнэт цаасны арилжааны төлбөрийн;

1.4.8. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн;

1.4.9. үнэт цаасны арилжаа эрхлэх;

1.4.10. харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ;

1.4.11. хөрөнгө оруулалтын сангийн;

1.4.12. хөрөнгө оруулалтын менежментийн;

1.4.13. үнэт цаасны итгэмжлэн удирдах;

1.4.14. кастодианы;

1.4.15. санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоох;

1.4.16. Хорооноос зохицуулалттай гэж тооцсон бусад

1.5. Доорхи зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхэлж болно:

1.5.1. харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээг андеррайтерийн үйл ажиллагаатай;

1.5.2. андеррайтерийн үйл ажиллагааг кастодианы үйл ажиллагаатай;

1.5.3. тухай бүр Хорооноос зөвшөөрсөн үйл ажиллагаа.

1.6. Энэ журмын 1.5-д зааснаас бусад үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно.

1.7. Энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй хэд хэдэн үйл ажиллагааг нэг зохицуулалттай этгээд хавсран эрхлэх тохиолдолд тэдгээрт тавигдах санхүүгийн шаардлагыг хавсран эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрт тавигдах шаардлагаар нэмэгдүүлж тооцно.

1.8. Зохицуулалттай этгээд нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлэх бөгөөд эдгээрээс өөр төрлийн үйл ажиллагаа давхар эрхлэхийг хориглоно. [j1]

1.9. Энэ журмын 1.7 дахь заалт банкинд хамаарахгүй.

1.10. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16-д зааснаар Хороонд бүртгүүлсний дагуу гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэж болно.

1.11. Шашны болон төрийн бус байгууллага зохицуулалттай этгээдэд аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах, хувьцааг эзэмших, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

1.12. Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаагаа байнгын, тогтвортой, тасралтгүй явуулна.

1.13. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Хоёр. Зохицуулалттай этгээдэд тавигдах нөхцөл, [шаардлага][j2]

2.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээд нь [j3] дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. [Компанийн тухай хуулийн 13, 18-д заасны дагуу хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан байх][j4];

2.1.2. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд нь энэхүү журмын 8 дугаар хавсралтаар [тогтоосон][j5] хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангаж [ажиллана][j6].

2.1.3. зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх [захирал, мэргэжилтнүүд][j7] нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос мэргэжлийн эрх олгох журмын дагуу эрхлэх ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан байх;

2.1.4. дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байх бөгөөд тухайн ажилтан нь энэ журмын 2.1.3-д заасан эрх авсан, гүйцэтгэх захирал, брокер, дилер, үнэлгээ, төсөл, судалгаа, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлийн ажил үүргийг хавсран эрхэлдэггүй байх;

2.1.5. зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч /хувьцаат компанийн хувьд нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчид/, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан болон мэргэжилтнүүд нь дараах шалгуурыг хангасан байна:

2.1.5.1. ял шийтгэлгүй байх;

[j8] 2.1.5.2. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;

2.1.5.3. сүүлийн 5 жилд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагад ажиллаагүй байх;

2.1.5.4. зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь өөр байгууллагад үндсэн ажилтнаар давхар ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, өөр зохицуулалттай этгээдийн 5 хувь ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй байх;

2.1.5.5. энэ журмын 13 дүгээр зүйлд заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх./Энэ хэсгийг 2014 оны 05 дугаар сарын 07 ны өдрийн 150 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.1.6. зохицуулалттай үйл ажиллагаанд үүсч болзошгүй ашиг сонирхолын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамтай байх;

2.1.7. харилцагчдыг хүлээн авч үйлчлэх байрыг брокероос бусад ажиллагсдын албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байна. Ажилтны тоонд тохирсон шаардлага хангахуйц албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж, компьютер, хэвлэгч, хувилагч, бичлэг хийх боломжтой утас, факсын аппаратаар хангагдсан байх;

2.1.8. программ болон техник хангамж нь тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагааны дотоод журам, Хорооноос тогтоосон мэдээллийн нэгдсэн сангийн журам, нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан шаардлагад нийцсэн, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргах бүрэн боломжтой бөгөөд харилцагчтай байгуулсан гэрээ, харилцагчийн бүртгэл, тэдний хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох гүйлгээний мэдээллийг хадгалах боломжтой байх;

2.1.9. зуун хувь гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн [j9]боловсон хүчний 70-аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэдээс бүрдсэн байх.

2.1.10. зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

2.1.11. зохицуулалттай этгээдийн салбарын брокерийн үйлчилгээг анхан шатны зуучлагчаар дамжуулан гүйцэтгэж болох бөгөөд уг зуучлагч нь энэ журмын 2.1.3-д заасан эрх авсан байх шаардлагатай. Хууль тогтоомжоор хориглоогүй бол уг ажилтан нь анхан шатны зуучлалын үйлчилгээг үндсэн ажилтайгаа хавсран эрхэлж болно[j10].

2.1.12. энэ журмын 2.1.5-д заасан шалгуурыг тодорхойлохдоо дараах мэдээллийг үндэслэнэ:

2.1.12.1. тухайн этгээдээс ирүүлсэн өргөдөл, холбогдох бичиг баримт;

2.1.12.2. татварын өргүй талаарх татварын байгууллагын тодорхойлолт;

2.1.12.3. ял шийтгэлгүй талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

2.1.12.4. хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт;

2.1.12.5. гүйцэтгэх [захирал, мэргэжилтний] [j11] өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

2.1.12.6. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл.

2.1.13. гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээд нь тухайн орны онцлогоос шалтгаалан энэ журмын 2.1.5.1-2.1.5.3-д заасан мэдээллийг ирүүлэх боломжгүй бол гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигчдээс [j12] энэ тухай тодорхойлолтыг ирүүлнэ.

2.1.14. гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн хөрөнгө оруулагч нь гадаадын хуулийн этгээд бол тухайн орныхоо бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гадаадын иргэн бол овог нэр, оршин суух хаяг, холбоо барих утас, факс, цахимшуудангийн хаягийг ирүүлнэ.

2.2. Хороо шаардлагатай гэж үзвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 64.4-т заасны дагуу тухайн орны холбогдох байгууллагуудаас лавлагаа авч болно.

2.3. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47, 49 дүгээр зүйлд заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.3.1. үнэт цаасны арилжаа эрхлэх нэгжтэй байх;

2.3.2. дотоод хяналтын үйл ажиллагааг эрхлэх нэгжтэй байх;

2.3.3. шинээр гаргах үнэт цаасыг бүртгэх болон бүртгэлээс хасах үйл ажиллагааг эрхлэх нэгжтэй байх;

2.3.4. үнэт цаасны арилжааг хянах нэгжтэй байх;

2.3.5. мэдээлэл, технологийн нэгжтэй байх;

2.3.6. үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь үнэт цаасны төлбөрийн, тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх.

2.4. Үнэт цаасны тооцооныүйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан чиг үүргийг гүйцэтгэх болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.4.1. үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа явуулахадшаардлагатай програм хангамж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

2.4.2. үнэт цаасны тооцооны үйл ажиллагаагэрхлэх нэгжтэй байх;

2.4.3. мэдээлэл, технологийн нэгжтэй байх;

2.4.4. үнэт цаасны тооцооныэрсдлийн удирдлагын нэгжтэй байх;

2.4.5. үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааг [j13]эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь үнэт цаасны арилжааны, төлбөрийн болон төвлөрсөн хадгаламж, холбогдох кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх .

2.5. Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан чиг үүргийг гүйцэтгэх болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.5.1. үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа явуулахадшаардлагатай програм хангамж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

2.5.2. үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаагэрхлэх нэгжтэй байх;

2.5.3. үнэт цаасны төлбөрийн эрсдлийг тооцож үнэлэх нэгжтэй байх;

2.5.4. үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь арилжааны, тооцооны, хадгаламжийн болон

холбогдох кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх.

2.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцлийг хангасан байна:

2.6.1. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааг эрхлэх нэгжтэй байх;

2.6.2. дотоод мэдээлэл эзэмшигчдийн болон байгууллагын дотоод үйл ажиллагааг хянах, харилцагчдаас ирсэн санал гомдлыг шийдвэрлэх нэгжтэй байх;

2.6.3. мэдээлэл, технологийн нэгжтэй байх

2.6.4. үнэт цаасны хадгаламжийн эрсдлийг тооцож үнэлэх нэгжтэй байх;

2.6.5. үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь арилжааны, тооцооны болон холбогдох кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх.

2.7. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцлийг хангасан байна:

2.7.1. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг дагнан эрхлэх нэгжтэй байх;

2.7.2. дотоод мэдээлэл эзэмшигчдийн болон байгууллагын дотоод үйл ажиллагааг хянах, харилцагчдаас ирсэн санал, гомдлыг шийдвэрлэх нэгжтэй байх;

2.7.3. мэдээлэл, технологийн нэгжтэй байх;

2.7.4. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь арилжааны, тооцооны, хадгаламжийн болон холбогдох кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх.

2.8. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байх:

2.8.1. брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсч буй хуулийн этгээд нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна;

2.8.2. брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан хоёроос доошгүй ажилтантай байх.

2.9. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.9.1. дилерийн тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хуулийн этгээд нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;

2.9.2. дилерийн үйл ажиллагаа эрхлэх орон тооны ажилтантай байх.

2.10. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна үнэлгээ, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах гурваас доошгүй ажилтантай байх бөгөөд тэдгээр нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос эрхлэх ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан, бусад тусгай зөвшөөрөлтэй бусад ажил үйлчилгээ, дотоод хяналтын үйл ажиллагааг хавсран эрхэлдэггүй байх шаардлагыг хангасан байна. []

[j14]2.11. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.11.9. хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх орон тооны мэргэжилтэнтэй байх;

2.11.10. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний чиглэлээр байгуулах гэрээ, хэлэлцлийг боловсруулж, хянах орон тооны хуулийн мэргэжилтэнтэй байх;

2.11.11. энэ журмын 2.11.9-д заасан мэргэжилтэн нь журмын 2.1.3-д заасан үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авсан, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр ажилласан туршлагатай байх;

2.12. Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн гурваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдлээс хамгаалах сан байгуулна.

2.13. Энэхүү журмын 2.12-т заасан эрсдлийн сангийн харилцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 507 дугаар тогтоолоор баталсан “Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн тухай журам”-аар зохицуулна.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай бичиг баримт

3.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2-т зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

3.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

3.1.2. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тухай төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй хувьцаа эзэмшигчдийн хурал/ шийдвэрийн эх хувь эсхүлнотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.1.3. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч **хуулийн этгээдийн**[j15] улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.1.4. улсын бүртгэлд бүртгүүлсэн компанийн дүрэм. Тус дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна:

3.1.4.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;

3.1.4.2. хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;

3.1.4.3. хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн эрх, үүрэг, хариуцлага;

3.1.4.4. зохицуулалттай этгээдийн хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааны зохицуулалт;

3.1.4.5. зохицуулалттай этгээд татан буугдах үндэслэл, удирдлага, мэргэжилтнүүдийн буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.

3.1.5. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн [j16] хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт;

3.1.6. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн [j17] хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа;

3.1.7. брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт. [j18]

3.1.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам;

3.1.9. Хорооны зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар баталгаажуулсан [j19] сүүлийн улирлын санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс;

3.1.10. энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу 5 хувиас дээш хувьцаа эзэмшигч [j20] эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт;

3.1.11. гүйцэтгэх удирдлага болон мэргэжилтнүүд [j21] нь энэ журмын 2.1.3-д заасан эрхийн үнэмлэхийн хуулбар, энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу тэдгээрийн тухай тодорхойлолт;

3.1.12. хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнүүд энэ журмын 14 дүгээр зүйлд заасан тохиромжтой этгээд болох тухай мэдээлэл;

3.1.13. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол тухайн хуулийн этгээдийн хувьцааны арилжааны сүүлийн нэг жилийн арилжааны тайлан;

3.1.14. ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.1.15. энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу боловсруулсан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх гурваас доошгүй жилийн бизнесийн болон эрсдлийн удирдлагын төлөвлөгөө;

3.1.16. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга;

3.1.17. зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд зохицуулалттай үйл ажиллагаа тус бүрийг дотооддоо удирдан зохион байгуулах нэгжийн талаарх танилцуулга;

3.1.18. үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт, энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулсан ажлын байрны тодорхойлолт;

3.1.19. энэ журмын 2.1.6-д заасан зохицуулалттай үйл ажиллагаанд үүсч болзошгүй сонирхолын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам;

3.1.20. Хорооны холбогдох журмын дагуу зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журам;

3.1.21. банк, түүний толгой, хараат болон охин компани, банкны нэгдэлд орсон болон банкны хувьцааны тав болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй аливаа хуулийн этгээд нь зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн албан бичиг[j22].

3.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.2.2, энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтуудыг ирүүлнэ:

3.2.1. үндсэн үйл ажиллагаанд ашиглах програмын танилцуулга;

3.2.2. үнэт цаасны бүртгэлийн журам;

3.2.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47.2 дугаар зүйлд заасан дотооддоо мөрдөх журмууд;

3.2.4. арилжаа эрхлэх байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн анкет; /Энэ журмын 3-р хавсралтын дагуу бөглөж ирүүлнэ/.

3.2.5. арилжаа эрхлэх байгууллагын хувьцаа эзэмшигчдийн бүтэц; [j23]

3.2.6. хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагаас сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцохгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй талаарх баталгаа;

3.2.7. үнэт цаасны арилжааны төлбөрийн, тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээний төсөл;

3.2.8. гишүүнчлэлийн гэрээний төсөл;

3.2.9. програм хангамж, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны тодорхойлолтыг энэ журмын 4-р хавсралтын дагуу үйлдэж, түүнд техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээ, эсхүл нотариатаар баталгаажуулсан гэрээний хуулбар.

3.3. Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.3.1. үнэт цаасны төлбөрийн эрсдлийн удирдлагын журам;

3.3.2. хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдлээс хамгаалах сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцлийг тусгасан дотоод журам;

3.3.3. үнэт цаасны тооцооны болон хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

3.3.4. үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан төлбөрийн үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл;

3.3.5. үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн төлбөрийг хийж гүйцэтгэх журам, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам.

3.4. Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ.

3.4.1. үнэт цаасны тооцооны үйл ажиллагааны журам;

3.4.2. хөрөнгө оруулагчдыг тооцооны үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдлээс хамгаалах сан байгуулах сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцлийг тусгасан дотоод журам;

3.4.3. үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөрийн болон хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

3.4.4. үнэт цааснытооцооны үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан тооцооны үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл;

3.4.5. үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн дүнд үүссэн тооцоогтодорхойлох, төлбөрийг хийж гүйцэтгэх журам;

3.4.6. мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам.

3.5. Үнэт цаасны хадгаламжийн [24] үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.5.1. үнэт цаасныхадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх нэгжийн чиг үүргийг онцгойлон заасан үйл ажиллагааны журам;

3.5.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн хүрээнд дотооддоо мөрдөхжурам, зааврууд;

3.5.3. харилцагчдын хөрөнгийг эрсдлээс хамгаалах зорилгоор даатгалын байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

3.5.4. харилцагч байгууллагуудтай байгуулах хадгаламжийн гэрээний төсөл;

3.5.5. харилцагчийн үнэт цаас худалдсаны болон ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг байршуулан хадгалах арилжааны банктай байгуулах гэрээний төсөл;

3.5.6. харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ;

3.5.7. үнэт цаасны хадгаламж, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам;

3.5.8. Гишүүн кастодиантай мэдээлэл тасралтгүй солилцох, зах зээлийн хэвийнүйл ажиллагааг хангах тухай үйл ажиллагааны журам.

3.6. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.6.1. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааны журам;

3.6.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дотооддоо мөрдөхжурмууд;

3.6.3. харилцагчтай байгуулах өмчлөх эрхийн бүртгэлийнгэрээний төсөл;

3.6.4. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн харилцааг зохицуулсандотоод үйл ажиллагааны журам: Үүнд доорхи зүйлсийг тодорхой заана.

3.6.4.1. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл хийхэд үндэслэх бичиг, баримт, мэдээлэл;

3.6.4.2. харилцагчийн дансны хуулга, түүний хэлбэр, агуулга, хугацаа;

3.6.4.3. үнэт цаасыг харилцагчийн дансанд бүртгэх, үнэт цаасны өмчлөх эрхийнбүртгэл хийхэд үндэслэсэн бичиг баримтыг хадгалах заавар;

3.6.4.4. харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ;

3.6.4.5. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, шилжүүлэг, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам;

3.6.4.6. үнэт цаас гаргагчтай байгуулах үнэт цаасны бүртгэлийг хөтлөх гэрээний төсөл;

3.6.4.7. Шаардлагатай бусад бичиг баримт.

3.7. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.7.1. дараахьжурмыг эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулан ирүүлнэ:

3.7.1.1. брокерийн үйл ажиллагааны журам;

3.7.1.2. дотоод хяналтын үйл ажиллагааны тухай журам;

3.7.1.3. харилцагчдыг эрсдлээс хамгаалах үйл ажиллагааны тухай журам;

3.7.1.4. харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай журам.

3.7.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тухайн брокерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх гаргасан дүгнэлт.

3.8. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.8.1. дараажурмын эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хувийг ирүүлнэ:

3.8.1.1. дилерийн үйл ажиллагааны журам;

3.8.1.2. дотоод хяналтын үйл ажиллагааны тухай журам.

3.8.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тухайн дилерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх гаргасан дүгнэлт.

3.9. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.9.1. андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам. Тус журамд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4-д зааснаас гадна дараах төрлийн хэлбэрээр үнэт цаас гаргагчтай ажиллахыг тусгана:

3.9.1.1. хоёрдогч зах зээлд худалдах буюу өөрийн үнэт цаасны багцад хадгалах зорилгоор үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг бүхэлд нь худалдан авах;

3.9.1.2. үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасны зарим хэсгийг худалдан авах;

3.9.1.3. гаргасан үнэт цаасыг худалдан авахгүйгээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах;

3.9.1.4. гаргасан үнэт цаас нь анхдагч зах зээлд арилжигдах боломжгүй нөхцөлд үнэт цаасыг нь тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргах.

3.9.2. андеррайтерийн компани болон үнэлгээ, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах мэргэжилтний хооронд байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.10. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.10.1. хөрөнгө оруулалтын зөвлөх компани болон үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний хооронд байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.10.2. үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм;

3.10.3. үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх мэргэжилтний үнэтцаасны зах зээлд ажил, үйлчилгээ үзүүлэх эрхийн үнэмлэхийн хуулбар, мэргэшсэн байдлын тухай танилцуулга, нотлох баримт;

3.10.4. мэргэжилтний үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр сургалтад хамрагдаж мэргэшсэн тухай үнэмлэх, сертификат, дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.10.5. хөрөнгө оруулалтын зөвлөх компанийн хуулийн мэргэжилтний дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар.

3.11. гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөл хүсэхдээ энэ журмын холбогдох заалтуудад заасан бичиг баримтуудыг Монгол хэлээр үйлдэж ирүүлнэ.

3.12. тусгай зөвшөөрөл хүсч буй байгууллага нь ирүүлсэн бичиг баримтад өөрчлөлт оруулсан бол энэ тухай ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

Дөрөв. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдлийн бичиг баримтыг хянах

4.1. Хороо тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг хуанлийн 30 хоногт багтаан хянаж шийдвэрлэнэ.

4.2. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд заасан шаардлагуудыг хангаж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

4.3. Хорооны Ажлын алба нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт холбогдох бичиг баримтыг дараахь байдлаар хянана:

4.3.1. хувьцаа эзэмшигчийн оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны орлого, эх үүсвэрээс бүрдсэн эсэх;

4.3.2. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан эсэх;

4.3.3. зохицуулалттай этгээдийн гурван жилийн бизнес төлөвлөгөөнд үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдал, үйлчилгээний онцлог, харилцагч, хөрөнгө оруулагчийг татах, гадааддотоод хүчин зүйлсийг харгалзан үйл ажиллагааны бодит төлөвлөгөө боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргах;

4.3.4. компанийн дүрэм, үйл ажиллагааны болон дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан журам, зааварт нийцэж буй эсэх;

4.3.5. тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэхэд түүний бусад үйл ажиллагаатай харшлах эсэх, сонирхолын зөрчил үүсэх эсэх;

4.3.6. хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь журамд заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж буй эсэх;

4.3.7. брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн хувьд дотоод ажиллагааны горим, хяналтын зохих тогтолцоотой эсэх;

4.3.8. ажлын байр, техник, тоног төхөөрөмж, програм хангамж нь арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн нөхцөл, шаардлагыг хангасан талаарх дүгнэлт ирүүлсэн эсэх.

4.4. Хороо шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг, баримтын талаар холбогдох газраас тодруулах, дүгнэлт гаргуулах, лавлагаа авах эрхтэй.

4.5. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бичиг баримтын бүрдэл дутуу[j25], тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангаагүй бол тухайн компанид албан бичгээр мэдэгдэж нэмэлт бичиг баримтыгшаардаж болно.

4.6. Тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээдээс ирүүлсэн бичиг баримтыгдараахь тохиолдолд ажлын 10 хоногийн дотор тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд буцаана:

4.6.1[j26]. тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримт нь холбогдох хууль болон энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй;

4.6.2. тусгай зөвшөөрлийн бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон.

4.7. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг буцаах тохиолдолд өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

4.8. Энэ журмын 4.6.2-д заасан үндэслэлээр Хороо бичиг баримтыгбуцаасан тохиолдолд буцаасан өдрөөс хойш 1жилийн дотор уг хуулийн этгээд болон түүний хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагад ажиллаж байсан этгээдүүдээс тусгай зөвшөөрөлхүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

4.9. Энэ журмын 4.6.2-д зааснаас бусад үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсантохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагуудыг бүрэн хангасан гэж үзсэнхуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө Хороонд дахин гаргаж болно. Энэтохиолдолд тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дахин төлнө.

4.10. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш [j27]Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

Тав. Тусгай зөвшөөрөл олгох

5.1. Өргөдөл гаргагч нь дараахь нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд Хороо тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгоно:

5.1.1. хуулийн этгээд тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэхэд түүний бусад үйл ажиллагаатай харшлахгүй[j28], сонирхлын зөрчил үүсгэхгүй гэж үзсэн;

5.1.2. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд болох нь тогтоогдсон;

5.1.3. хүний нөөцийн хувьд Хорооноос тогтоосон шаардлага хангасан;

5.1.4. үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа эрхлэхэд хүрэлцэхүйц хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. “Зохицуулалттай этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн далаас доошгүй хувийг мөнгөн хөрөнгө, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “А” ангилалд хамаарах хувьцаа, Засгийн газрын богино хугацаат үнэт цаасаар бүрдүүлнэ. Үнэт цаас нь мөнгөн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байна”;

5.1.5. ажлын байр, техник болон програм хангамж нь тухайн үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангасан;

5.1.6. энэхүү журмын 8 дугаар хавсралтаар тогтоосон[j29] хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан;

5.1.7. Хорооноос тогтоосон бусад нөхцөл, шаардлагыг хангасан.

5.2. Тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

5.3. Хорооны Үнэт цаасны газрын даргын томилсон ажлын хэсэг тусгай зөвшөөрөл хүсч буй этгээдийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, програм хангамж нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргана.

5.4. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, энэ журмын дагуу хянаж, Ажлын албанаас санал, дүгнэлт боловсруулан Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.5. Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэнхөрөнгөд оногдох мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг зохицуулалттай этгээдийн[j30] холбогдох удирдлагад албан бичгээр мэдэгдэнэ.

5.6. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хувь нийлүүлсэнхөрөнгөд оногдох мөнгөн хөрөнгийг ажлын 3 хоногт багтаан Хорооны дансанд төвлөрүүлж, хуанлийн 10 хоног байршуулах бөгөөд мөнгөн хөрөнгөд Хороо хүү төлөхгүй.

5.7. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэнхөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн байгууллагын албан ёсны хүсэлт, нэхэмжлэлийг үндэслэн тухайн зохицуулалттай этгээдийн харилцах дансанд буцаан шилжүүлнэ.

5.8. Хорооны шийдвэр болон тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, хувь нийлүүлсэнхөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн баримтыг тус тус үндэслэн тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

Зургаа. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийгнэмж олгох

6.1. Үнэт цаасны зах зээлд энэхүү журмын 1.4-д заасан зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь шалгуурыг хангасан зохицуулалттай этгээдэд нэмж олгоно:

6.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журмуудад заасан шаардлагыг бүрэн хангасан байх;

6.1.2. Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн дөрвөн улирал дараалан хангаажжилласан байх.

6.2. Зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд нэмж эрхлэх үйл ажиллагааг тусгаж, дараахь бичиг баримтуудын хамт Хороонд ирүүлнэ:

6.2.1. тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх талаарх хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, нэмж шаардагдах хувь нийлүүлсэн хөрөнгө, зардал, тэдгээрийн эх үүсвэрийн тооцоо, гурван жилийн бизнес болон эрсдлийн төлөвлөгөө;

6.2.2. зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

6.2.3. хавсран эрхлэх зохицуулалттай үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагааны эрсдлийг тооцох аргачлал, харилцагчдын хохирлыг барагдуулах зохицуулалтыг тусгасан дотоод журам;

6.2.4. зохицуулалттай этгээд нь брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж хүссэн тохиолдолд энэ журмын 3.7.2, 3.8.2-т заасан тодорхойлолт;

6.2.5. энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд тусгай зөвшөөрөл бүрт шаардагдах баримт бичиг

6.3. Хорооны Ажлын албанаас зохицуулалттай үйл ажиллагаа хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг хянан шалгаад, энэ нь тухайн байгууллагын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй, харилцагчдад нь аливаа хохирол учруулахгүй, боловсон хүчний болон техник, тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд эрхлэх нөхцлийг хангаж байна гэж үзвэл уг тусгай зөвшөөрлийг олгох шийдвэрийг Хороо гаргана.

6.4. Хорооны шийдвэр гарсны дараа хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг Ажлын албанаас албан бичгээр мэдэгдэнэ.

6.5. Хувьцаа эзэмшигч нь тус албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд 10 хоногийн хугацаанд байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

6.6. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг 10 хоногт Хорооны дансанд төвлөрүүлсэн талаарх баримт, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг тус тус үндэслэн Хороо тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, холбогдох журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

6.7. Хороо энэ журмын 6.3-д заасан нөхцлийг хангаагүй гэж үзвэл тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзаж, албан бичгээр мэдэгдэнэ.

6.8. Энэ журмын 6.7-д зааснаар Хороо татгалзснаас хойш хүсэлт гаргагч өргөдлөө журмын шаардалагад нийцүүлэн Хороонд дахин хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд заасан тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дахин төлнө.

Долоо. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах

7.1. Зохицуулалттай этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно:

7.1.1. хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгөөр;

7.1.2. зохицуулалттай этгээд үндсэн үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаар нэмж хөрөнгө оруулах;

7.1.3. хувьцаа нэмж гаргах;

7.1.4. хуулиар зөвшөөрөгдсөн бусад хэлбэр.[j31]

7.2. Хувь нийлүүлсэн хөрөнгөд зөвхөн Хорооны зөвшөөрлөөр өөрчлөлт оруулах бөгөөд өөрчлөлт оруулах хүсэлтийг дараах бичиг баримтынхамт Хороондирүүлнэ:

7.2.1. өөрчлөлт оруулах болсон эрх зүйн үндэслэлийг нотлох баримт;

7.2.2. зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдөж байгаа бол энэ журмын 2.1.12-д заасан тохиромжтой этгээдийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг ирүүлэх;

7.2.3. зохицуулалттай этгээдийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл, түүний нотлох баримт;

7.2.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан бусад мэдээлэл, тодорхойлолт;

7.2.5. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийг өөрчлөхтэй холбогдуулан зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийн төсөл;

7.2.6. Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд заасан зохицуулалтын үйлчилгээний хураамж төлсөн баримт.

7.3. Зохицуулалттай этгээдийн энэ журмын 7.2-т заасан хүсэлт, холбогдох бичиг баримтыг Хорооны Ажлын алба холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, саналаа Хорооны даргад танилцуулах бөгөөд зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэрийг [Хорооны дарга][j32] гаргана.

7.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийг хорогдуулах нь зохицуулалттай этгээдийн санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, компанийн хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй гэж үзвэл Ажлын албасанал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулна. Хорооны дарга хувь нийлүүлсэн хөрөнгийг хорогдуулах зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэрийг гаргана.[j33]

7.5. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох эсэхийг ажлын 14 хоногт шийдвэрлэнэ. Энэ журмын 7.2-т заасан бичиг баримт нь зохих шаардлага хангасан гэж үзвэл хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг галбан бичгээр зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал болон хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

7.6. Энэ журмын 7.5-д заасан албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор холбогдох мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд [10 хоногийн хугацаагаар байршуулах][j34] ба энэхүү мөнгөн хөрөнгөд Хороо хүү төлөхгүй.

7.7. Энэхүү журмын 7.6-д заасан хөрөнгийг Хорооны дансанд байршуулсан болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг тус тус үндэслэн Хороо тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, холбогдох журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

7.8. Зохицуулалттай этгээд нь хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол энэ зүйл [хамаарахгүй][j35].

Найм. Зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөх

8.1. Зохицуулалттай этгээд нь оноосон нэрээ өөрчлөх тохиолдолд Хороонд дараахь бичиг баримтыг хүсэлтийн хамт ирүүлнэ:

8.1.1. зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

8.1.2. улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулсан хуудас;

8.1.3. дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

8.1.4. Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд заасан [36]зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт;

8.1.5. Оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгаан, нөхцлийн талаарх танилцуулга.

8.2. Хороо энэ журмын 8.1-д заасан бичиг баримт бүрэн гүйцэд бүрдсэнээс хойш өргөдлийг ажлын 10 хоногийн дотор хянана.

8.3. Хороо оноосон нэрийн өөрчлөлт нь зохицуулалттай этгээдийн харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл уг өөрчлөлтийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

8.4. Энэ журмын 8.3-т заасан шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, шинээр олгож, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

Ес. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг томилох, өөрчлөх

9.1. Арилжаа эрхлэх болон төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагын гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөх тухай шийдвэрийг Хороо, бусад зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөх тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана. */Энэ хэсгийг 2014 оны 05 дугаар сарын 07 ны өдрийн 150 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.2. Гүйцэтгэх захирлаар томилогдох этгээд нь дараахь шаардлагыг хангасан байна:

9.2.1. дээд боловсрол эзэмшсэн байх;

9.2.2. удирдах ажлын туршлагатай байх;

9.2.3. энэ журмын 2.1.3, 2.1.5-д заасан шалгуурыг хангасан байх.

9.3. Энэ журмын 9.1-д зааснаар Хорооноос зөвшөөрөл авах этгээд нь дараахь бичиг баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

9.3.1. гүйцэтгэх захирлаар томилох этгээдийн товч намтар, анкет /энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу ирүүлнэ/;

9.3.2. дээд боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

9.3.3. өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

9.3.4. үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхийн хуулбар;

9.3.5. гүйцэтгэх захирлаар томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар;

9.3.6. энэ журмын 2.1.12-д заасан тодорхойлолт. */Энэ хэсгийг 2014 оны 05 дугаар сарын 07 ны өдрийн 150 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.4. Энэ журмын 9.1-д заасан шийдвэрийг гаргахдаа мөн журмын 13-д заасан тохиромжтой этгээдэд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үндэслэл болгоно. */Энэ хэсгийг 2014 оны 05 дугаар сарын 07 ны өдрийн 150 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.5. Журмын 9.4 дэх хэсгийг үндэслэн Ажлын алба тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж холбогдох бүртгэлд бүртгэнэ.

9.6. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа этгээд нь энэ журмын 9.2-т заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр зөвшөөрөл өгөхөөс татгалзсан тохиолдолд тухайн зохицуулалттай этгээд гүйцэтгэх захирлыг томилох зөвшөөрөл авахаар 1 сарын дотор өөр этгээдийг санал болгоно.

Арав. Зохицуулалттай этгээдэд [салбар нээн ажиллуулахыг [j37] зөвшөөрөх, хүчингүй болгох

10.1. Зохицуулалттай этгээд нь салбар нээн ажиллуулах тухай өргөдлөө Хороонд өгнө.

10.2. Зохицуулалттай этгээдийн салбар нь зөвхөн тухайн зохицуулалттай этгээдийн оноосон нэрийгхэрэглэх бөгөөд салбарын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хүрээ, ажиллах журмыг зохицуулалттай этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл/байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно.

10.3. Зохицуулалттай этгээд нь энэ журмын 10.1-д заасан зөвшөөрөлгүйгээр салбарын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

10.4. Гадаадын үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр салбар, төлөөлөгчийн газраа нээх тохиолдолд Хорооноос зөвшөөрөл авна.

10.5. Салбар байгуулах зохицуулалттай этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

10.5.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан[j38];

10.5.2. сүүлийн хоёр улиралд Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан; [j39]

10.5.3. салбар нь үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалт, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах эрх авсан орон тооны салбарын эрхлэгч, мэргэжилтэнтэй байх.

10.6. зохицуулалттай этгээд нь салбар нээх зөвшөөрөл хүсэхдээ дараахьбичиг баримтыг Хороонд ирүүлнэ:

10.6.1. салбар нээх тухай хүсэлт;

10.6.2. төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэр;

10.6.3. салбарын гүйцэтгэх удирдлага, мэргэжилтний тодорхойлолт, Хорооноос олгосон эрхийн үнэмлэх,иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар болон энэхүү журмын 2.1.12-д заасан тодорхойлолт;

10.6.4. салбарын дотоод хяналтыг хэрэгжүүлэх болон салбарын үйл ажиллагааг зохицуулах журам;

10.6.5. салбарын үйл ажиллагаа явуулах ажлын байр, үйл ажиллагаандашиглах тоног төхөөрөмж, програм хангамжийн талаарх танилцуулга;

10.6.6. Хорооноосшаардсан бусад бичиг баримт.

10.7. Ажлын алба энэ журмын 10.6-д заасны дагуу ирүүлсэн бичиг баримтыг хянан үзэж, салбар байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй,үйлчлүүлэгчдэд хохирол учруулаагүй, боловсон хүчин, тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг хангасан гэж үзвэл Хорооны дарга зөвшөөрөл олгоно.

10.8. Зохицуулалттай этгээд нь салбараа татан буулгах, үйл ажиллагааг нь хязгаарлах, өөрчлөн байгуулах, байршлыг нь өөрчлөхтухай бүрт компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрийг гаргуулж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

10.9. Зохицуулалттай этгээдийн салбар нээх тухай Хорооны даргын шийдвэр, Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд заасан тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлсөн баримтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд салбарын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

10.10. Зохицуулалттай этгээд нь **салбарын үйл ажиллагааны тайлан**г улирал тутам Хороонд ирүүлнэ [j40].

10.11. Хорооны дарга тухайн зохицуулалттай этгээдийн салбар санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооны Ажлын албанаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн салбарын санхүүгийн байдал зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл салбарын үйл ажиллагааг зогсооно.

10.12. Зохицуулалттай этгээдийн салбарын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ:

10.12.1. салбар татан буулгах тухай зохицуулалттай этгээдийн шийдвэр;

10.12.2. тухайн салбарын үйл ажиллагаа нь зохицуулалттай этгээдийн хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосон Хорооны Улсын байцаагчийн дүгнэлт;

10.12.3. Хорооноос салбарын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 1 сарын хугацаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхлээгүй;

10.12.4. салбарын үйл ажиллагааг [j41] зогсоосон;

10.12.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.13. Зохицуулалттай этгээдийн салбар нь тухайн газар тогтмол, байнгын үйл ажиллагаа явуулна.

10.14. Зохицуулалттай этгээд салбарын үйл ажиллагааг зогсоох үндэслэл болсон зөрчлийг арилгаж, зохих шаардлагыг хангасны дараа салбар нээх хүсэлтийг дахин хүлээж авах бөгөөд Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд заасан **зохицуулалтын үйлчилгээний хөлсийг** [j42] хүсэлт гаргах бүрдээ журамд заасан хэмжээгээр төлнө.

10.15. Орон нутагт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд нь Улаанбаатар хотод салбар нээх тохиолдолд журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Арван нэг. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

11.1. Хороо тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-т зааснаас гадна дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

11.1.1. нэг жилийн хугацаанд арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлд элсээгүй;

11.1.2. хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон, хохироох болзошгүй нөхцөл байдал үүссэн;

11.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл хангахгүй болсон;

11.1.4. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хагас болон жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр дараалан хангаж ажиллаагүй;

11.1.5. хагас болон жилийн санхүүгийн тайлан тэнцлийг холбогдох тодруулгын хамт ирүүлээгүй;

11.1.6. Хорооноос мэдээллийн сангийн журмын дагуу шаардсан мэдээллийг удаа дараа хугацаанд нь гаргаж өгөөгүй болон алдаатай, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн;

11.1.7. Хорооны 2007 оны 156 дүгээр тогтоолд заасан зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлс төлөх хугацааг нэгээс дээш сараар хэтрүүлсэн;

11.1.8. зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд,эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд биш болсон;

11.1.9. хууль, Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн талаар үнэт цаасны арилжаа эрхлэх болон үнэт цаасны хадгаламжийн байгууллага, бусад эрх бүхий өөрийгөө зохицуулагч байгууллагаас үндэслэл бүхий хүсэлт гаргасан;

11.1.10. журмын 1.7, 1.8-д заасан шаардлагыг хангаж ажиллаагүй;

11.1.11. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

11.1.12. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

11.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтээ Хороонд ирүүлнэ. Хорооноос тусгай зөвшөөрлийг

түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрлийг сэргээх бөгөөд хэрэв тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хүсэлт ирүүлээгүй тохиолдолд Ажлын алба тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар Хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

11.3. ХорооАж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-т зааснаас гадна дор дурьдсан тохиолдолд зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

11.3.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;

11.3.2. зохицуулалттай этгээд дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болж татан буугдах тухай эрх бүхий байгууллага болох шүүх, зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан;

11.3.3. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахад харшлах бусад нөхцөл байдал үүссэн;

11.3.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаж, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

11.3.5. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.

11.4. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд:

11.4.1. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, “ХҮЧИНГҮЙ” тэмдэг дарж тухайн зохицуулалттай этгээдийн хувийн хэрэгт хавсарган, холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ;

11.4.2. тусгай зөвшөөрөл дахин олгохтой холбоотой хүсэлтийг тухайн байгууллагаас нэг жилийн дотор хүлээн авахгүй.

Арван хоёр. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

12.1. Хороо нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн болон хүчингүй болгосон шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор зохих журмын дагуу энэ тухай нийтэд мэдээлнэ.

12.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд харилцагчдыг шилжүүлэх ажиллагааг Хорооны 2008 оны 221 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх тухай түр журам”-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

12.3. Хороо шаардлагатай гэж үзвэл тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн этгээдээс харилцагчийн дансанд нэвтрэх, гүйлгээ хийх эрхийг хязгаарлах, эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, тусгаарлах, арга хэмжээг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлж болно.

12.4. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хороо тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон хуулийн этгээдээс үйлчлүүлэгчийнхээ дансанд нэвтрэх, гүйлгээ хийх эрхийг хязгаарлах, түүний хөрөнгийг битүүмжлэх, эрхэлж байсан үйл ажиллагаатай нь холбоотой баримтыг хамгаалалтад авах, архивт шилжүүлэх арга хэмжээг авч болно.

12.5. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нь тухайн зохицуулалттай этгээдээс бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийг дуусгавар болгох буюу уг гэрээ хэлцлээр хүлээсэн, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд харилцагчдад учирсан хохирлыг зохицуулалттай этгээд болон түүний эрх бүхий албан тушаалтан хариуцна.

12.6. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрөл бүхий бусад үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш ажлын 45 өдрийн дотор татан буугдах эсэх асуудлаа хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.

12.7. Энэ журмын 12.6-д заасан хугацаанд татан буугдах эсэхээ шийдвэрлээгүй зохицуулалттай этгээдийг албадан татан буулгах шийдвэр гаргуулахаар Хороо шүүхэд нэхэмжлэл гаргана.

12.8. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэнээс хойш зохицуулалттай этгээд дараахь үйлдэл хийхийг хориглоно:

12.8.1. шинээр гэрээ байгуулах;

12.8.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах.

12.9. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

12.9.1. брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараахь бичигбаримтыг архивын журмын дагуу нэгж болгон цэгцэлж, хавтаслан арилжаа эрхлэх байгууллагын архивт хүлээлгэн өгнө:

12.9.1.1. үйл ажиллагаа явуулсан хугацаанд харилцагчдаас хүлээн авсан үнэт цаас худалдах, худалдан авах захиалгын гэрээнүүд;

12.9.1.2. мөн хугацааны захиалгын бүртгэлүүд;

12.9.1.3. мөн хугацааны дилерийн даалгаварууд;

12.9.1.4. мөн хугацааны харилцагчдийн бүртгэлүүд;

12.9.1.5. мөн хугацаанд харилцагчдад мөнгө олгосон бүртгэл, мөнгөн хөрөнгийн баримтууд, түүний дотор мөнгө хүссэн өргөдлүүд;

12.9.1.6. харилцагчийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой бусад үндсэн баримтууд;

12.9.1.7. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт заасан бусад баримтууд.

12.10. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт хүлээлгэн өгөх баримт бичиг, хугацааны талаар тодорхой заана.

12.11. Энэ журмын 12.9.1 болон Хорооны шийдвэрт заасан бичиг баримтыг зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас харилцагчдад учруулсан хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн хувьцаа эзэмшигч, хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хувьцаат компани бол тухайн үеийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан эрх бүхий этгээдүүд хариуцаж барагдуулна.

Арван гурав. Тохиромжтой этгээдийг тодорхойлох

13.1. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 68.1-д заасан шалгуурыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж үзнэ:

13.2. Энэ журмын 13.1-д заасан шалгуурыг дараахь байдлаар ойлгоно:

13.2.1. санхүүгийн зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;

13.2.2. санхүүгийн зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг ижил төстэй байгууллагын эрх бүхий албан тушаалтан бус байх;

13.2.3. Хороо болон түүний Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан биш байх;

13.2.4. энэ журмын 2.1.5.3-т заасан шалгуурыг хангасан байх.

13.3. Хороо тохиромжтой этгээдийн шалгуурыг тодорхойлохдоо шаардлагатай нотлох баримтыг үндэслэнэ. Монгол Улсын болонгадаад улсын Засгийн газрын агентлаг, мэргэжлийн байгууллага, зохицуулалтын бусад байгууллага, хууль хяналтын байгууллагаас мэдээлэл лавлагаа авч болно.

13.4. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эрхлэх, эсхүл эрх бүхий албан тушаалтнаар томилогдох хүсэлт гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан нь өөрийгөө тохиромжтой этгээд болохоо нотлох баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлэх үүрэгтэй.

13.5. Үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь энэ журамд заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг байнга хангаж ажиллана. Тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд улсын байцаагч, хянан шалгагч нар зайны болон газардээрх хяналт шалгалтаар байнгын хяналт тавина.

13.6. Хороо тусгай зөвшөөрөл олгосны дараа тухайн тохиромжтой этгээдийн шаардлага хангахгүй болсон этгээдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

13.7. Удирдах албан тушаалтан өөрчлөгдсөн өөртүүнийг түр орлон гүйцэтгэх этгээд томилогдсон тохиолдолд тухайн этгээд нь тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байна.

Арван дөрөв. Хяналт хариуцлага

14.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

14.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

14.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-ын 1 дүгээр хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо :

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
Засгийн газрын IV байр
Бага тойруу -6
Улаанбаатар -210646
Монгол улс.

Хэнээс:
.....
.....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

.....
/зохицуулалттай этгээдийн нэр/ /ХК, ХХК/

Зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч шинээр мэргэжлийн байгууллага үүсгэн байгуулах зорилгоор хурал хийж, үнэт цаасны зах зээлд дор дурдсан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

- 1/
- 2/

/зохицуулалттай үйл ажиллагааны төрөл/

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхэд дараах хуулийн этгээд, хуулийн этгээдийнхувьцаа эзэмшигч иргэд тус зохицуулалттай этгээдэд хөрөнгө оруулахаар шийдвэрлэв.

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	/Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигчид нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх удирдлагад /гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс ажиллах болно. Үүнд:

№	Овог, нэр	Эрхэлж буй ажил	Регистрийн дугаар	Зохицуулалттай этгээдэд эрхлэх албан тушаал

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бүрдүүлж хүргүүлсэн баримт материалуудыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл орсон хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/..... / /..... /
 /гарын үсэг/ /овог, нэр /

Хуулийн этгээд бол:

/тамга тэмдэг/

.....
/хуулийн этгээдийн нэр/

.....
/албан тушаал /

/...../
/гарын үсэг/

/...../
/овог, нэр/

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 2 дугаар хавсралт

**ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИД БОЛОН ТУЗ-ЫН ДАРГА, ГИШҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

А. Зохицуулалттай этгээдийн ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

- 1. Хувьцаа эзэмшигч
- 2. Нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч
- 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн
 - дарга
 - гишүүн

Б. Хувьцаа эзэмшигчийн талаар.

1. Хувьцаа эзэмшигч нь:

Хуулийн этгээд Иргэн

2. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:

Энгийн хувьцаа

Давуу эрхтэй хувьцаа

..... / / төгрөг
/тоогоор/ /үсгээр/

3. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ. Үүнд:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- ТУЗ-ын дарга, гишүүдийн овог нэр, регистрийн дугаар:
- Хувь нийлүүлэгчдийн овог нэр, регистрийн дугаар:
- Эрхэлж буй үйл ажиллагааны төрөл:
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга.

/эрхэлж ирсэн үйл ажиллагааг хугацаагаар нь, хараат буюу охин компанитай буюу нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.


- Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлсэн хөрөнгийн танилцуулга, тодорхойлолт.
..... нь зохицуулалттай этгээдийн хувьцаа

Хуулийн этгээдийн нэр

эзэмшигч болж тус зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулж байгаа /үсгээр төгрөг нь манай хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

4. Хувьцаа эзэмшигч нь иргэн бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Овог, нэр:
- Төрсөн он, сар, өдөр:



- Иргэний харъяалал:
- Гэрийн хаяг:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажилд орсон он, сар, өдөр	Шалтгаан

5. Хувь нийлүүлэгчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн байдал:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Эрхлэж буй албан тушаал

.....овогтой миний бие зохицуулалттай этгээдийн хувьцааэзэмшигч болж хувь нийлүүлж байгаа /үсгээр/ төгрөг нь миний хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн

зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

Нэгдмэл сонирхолтой этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

. Зохицуулалттай этгээдийг төлөөлж
/албан тушаал/

/ / / /
/гарын үсэг/ /овог, нэр/


“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 3 дугаар хавсралт

**ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, НЭГЖИЙН
УДИРДЛАГА БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ**

1. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага бусад боловсон хүчин

нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Овог, нэр:
- Эрхлэх албан тушаал:
- Төрсөн он, сар, өдөр:
- Иргэний харъяалал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:
- Регистрийн дугаар:
- Одоо эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар */Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/*



Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажилд орсон он, сар, өдөр	Шалтгаан

- гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг

төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдтэй харьцаж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх одоо хууль хяналтын байгууллагад хэрэг

үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

2. Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Нэгдмэл сонирхолтой этгээд гэдгийг Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд тодорхойлсноор ойлгоно.

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Эрхлэж буй албан тушаал

Нэгдмэл сонирхолтой этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

Гүйцэтгэх удирдлага боловсон хүчний талаарх хууль хяналт, татвар, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагаа зэргийг хавсаргав.

..... зохицуулалттай этгээдийг төлөөлж

/албан тушаал/

*/..... /
/гарын үсэг/*

*/..... /
/овог, нэр/*

*“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 4 дүгээр хавсралт*

**ПРОГРАМ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д / Д	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн алин болох	Тоо ширхэг

Зохицуулалттай этгээд нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна үнэт цаасны арилжааны, төлбөр тооцооны, хадгаламжийн болон бусад.
. (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон –Г.
. (худалдан авсан, эсхүл худалдан авах гэрээ хийсэн) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн
. (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаа явуулах байрыг:

- худалдан авсан
- түрээслэсэн

бөгөөд энэхүү байр нь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

Ажлын байрны шаардлага болон харуул хамгаалалтын найдвартай байдлыг хангасан гэж үзэж дор дурдсан бичиг баримтуудыг хавсаргав.

Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ

Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ

Харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар

..... зохицуулалттай этгээдийг төлөөлж

/албан тушаал/

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр/

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 5 дугаар хавсралт

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь зохицуулалттай этгээдийн зорилгозорилтуудыг тодорхойлж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2. Зохицуулалттай этгээд нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйлажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах зүйлүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

2.1. үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, мэргэжлийн байгууллагын хэтийн төлөв байдал;

2.2. үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэхь боломжит нөхцөлүүд;

2.3. зохицуулалттай этгээдийн тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3-5 жилийн төсөөлөл;

2.4. актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, энэ талаар баримтлах бодлого;

2.5. үйл ажиллгаатай холбогдон гарах эрсдлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ.

3. Бизнес төлөвлөгөөг үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулж

эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

4. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Нүүр хуудас

Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- Мэргэжлийн байгууллагын нэр, хаяг
- Бизнес төлөвлөгөөний нэр
- Хувилбарын дугаар
- Боловсруулсан огноо
- Зохиогчийн нэр, хаяг
- Зохиогчийн тэмдэглэл
- Зохицуулалттайэтгээдийн удирдлагын нэр, хаяг

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагын тухай, хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэгт ямар үйлчилгээ үзүүлэх, ямар үр дүнд хүрэхийг ойлгомжтой тодорхойлсон байна.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтонд хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

2. БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн мэргэжлийн байгууллагын нэр, хаяг, өсөж хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба байдал бизнес төлөвлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес ба түүний түүх
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал
- Одоо явуулж байгаа үйл ажиллагаа
- Удирдлага боловсон хүчин
- Санхүүгийн төлөв байдал
- Бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго

3. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний “маркетингийн төлөвлөгөө”-нд дараах гурван хэсгийг багтаана.

3.1. Зах зээлийн шинжилгээ

Маркетингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд юуны түрүүнд зах зээл буюу хэрэглэгчдийнхээ тухай судалж мэдэх, өрсөлдөгчид, түншүүд, зуучлагчдынхаа талаар судлах ёстой.

3.2. Маркетингийн стратеги

Маркетингийн стратеги гэдэг нь зах зээл рүү хандсан төлөвлөгөө буюу амжилт олохын тулд танай байгууллагын хэрэглэж буй арга замууд.

3.3. Маркетингийн иж бүрдэл

Танай байгууллага зах зээл рүүгээ хандах арга зам буюу стратегийг тодорхойлсон бол одоо зах зээл дээр таатай байдал үүсгэхийн тулд байгууллагын ашигладаг хүчин зүйлс буюу маркетингийн иж бүрдлийг хэрхэн бүрдүүлэх вэ? Маркетингийн иж бүрдэлд үйлчилгээ, үнэ, идэвхжүүлэлт, хуваарилалтын талаар тусгана.

4. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ зэрэг асуудлуудыг багтааж оруулна.

Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт удирдах багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямар болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр хангасан болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулна. Удирдах багийн болон мэргэжилтэн (хуулийн зөвлөх г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн удирдах багийн гишүүн бүрийн эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргадгийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө хавсаргаж болно.

Зохион байгуулалтын бүтэц: Удирдах багийн дор зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт

олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажилтнууд ажлынхаа үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэхүү зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож бизнес төлөвлөгөөндөө оруулна.

Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөнө.

Энэ хэсэгт нийт ажиллагчид болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажилтны тоо, нийт ажилтны сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

Сургалтанд зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

5. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд :

- Нийт орлогын тооцоо;
- Үйлт орлогын тооцоо; д дараах хэсгүүд о
- Ашиг/ алдагдлын тооцоо;
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо;
- Мөнгөн урсгалын тооцоо орно.

6. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

6.1.Эрсдэлийн төрлүүд:

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд 4 төрлийн үндсэн эрсдэлийг тооцоолно. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмжийн
- Санхүүгийн буюу зээлийн
- Хүний хүчин зүйлийн
- Хууль зүйн

6.2.Эрсдэлийг багасгах боломжууд

Эдгээр эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ?

Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих. Даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж бичнэ. Даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд мэргэжлийн байгууллагын ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулна.

---o0o---

*“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 6 дугаар хавсралт*



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ____ оны ____ сарын ____ өдрийн ____ дугаар тогтоолоор _____-д

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

Энэхүү гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

_____ ТООТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд зориулсан
тэмдэглэлүүд

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт
хүчинтэй).

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр:

ХОЁР. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас, факс, и-мэйл хаяг	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ГУРАВ. Тусгай зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ДӨРӨВ. Зохицуулалттай этгээдийн салбарын тэмдэглэл:

Д/д	Салбарын хаяг	Хаягийн өөрчлөлт	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

--	--	--	--	--	--

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

ЗУРГАА. Хувьцаа эзэмшлийн талаар:

Д/д	Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эзэмшлийн дүн	Хувь	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 7 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН САЛБАРЫН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .
. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын _____ оны _____ сарын _____ өдрийн _____ дугаар тушаалыг үндэслэн _____ хот/аймаг дахь _____ тоот регистрийн дугаар бүхий _____ тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй _____ оноосон нэр бүхий ХХК-д _____ хот/аймаг - ийн _____ дүүрэг/сум - _____ нд

(Зохицуулалттай этгээдийн салбарын нэр)
байгуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйлажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8 дугаар хавсралт /Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 328 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

**ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ**

Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ:

- 1) Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа – 30,0 сая төгрөг;
- 2) Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа – 100,0 сая төгрөг;
- 3) Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа – 200,0 сая төгрөг;
- 4) Андеррайтерийн үйл ажиллагаа – 1,000,0 сая төгрөг;
- 5) Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 6) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 7) Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 8) Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа – 2,000,0 сая төгрөг;
- 9) Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/ – 1,000,0 сая төгрөг.”

5) Дээрх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нэг зохицуулалттай этгээд хавсран эрхлэх тохиолдолд тэдгээрт тавигдах санхүүгийн шаардлагыг хавсран эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрт тавигдах шаардлагаар нэмэгдүүлж тооцно.

6) Энэхүү хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлт нь 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө. */Энэ хэсгийг 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 150 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*